



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/649

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 75 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд ковид-19 цар тахлын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн Ховд Их Сургуулийн оюутны дотуур байрыг түр эмнэлэгийн зориулалтаар ашиглахад хийсэн тусгаарлах шилэн хаалтны үнэд 1 662 640 төгрөг /нэг сая зургаан зуун жаран хоёр мянга зургаан зуун дөч/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 1 662 640 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 оны батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
11 дүгээр сарын сарын 02-ны өдрийн  
А/649 дүгээр захирамжийн хавсралт



ТҮР ЭМНЭЛЭГИЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХАД ХИЙСЭН  
ТУСГААРЛАХ ШИЛЭН ХААЛТНЫ ҮНЭ

№	Хүлээн авах байгууллагын нэр	Зориулалт	Нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүний нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт дүн /мянган төгрөг/
1.	"Улаан бүрд" ХХК	Түр эмнэлгийн өрөөний тусгаарлалт	Хуванцар хаалт /метр/кв/	3.979	220000.00	875380.00
			Хаалга /хоёр онгойдог/ /метр/кв/	3.5787	220000.00	787314.00
	Нийт дүн					1662694.00

-оОо-